



“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК



Улаанбаатар хот

2020 он

I. Ерөнхий мэдээлэл

Байгуулагдсан огноо:	1999.01.18
Үйл ажиллагааны чиглэл:	Бизнесийн зөвлөгөө өгөх Гадаад худалдаа
Улсын бүртгэлийн дугаар:	9010387001
Регистрын дугаар:	2116812
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	45 хувьцаа эзэмшигчид 39,885 хувьцаа эзэмшиж байна /2019.04.08-ны өдрийн бүртгэлийн өдрөөрх тархалтын судалгаа/
Хаяг	Хан-Уул дүүрэг, Махатма Гандигийн гудамж, Галакси Тауэр, 902 тоот
Утас:	75753302, 99042846

II. Компанийн бизнесийн үйл ажиллагаа

“Хот девелопмент” ХК нь хяналтын багцийг эзэмшигч БиДиСек ҮЦК ХК болон нэгдмэл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран нь цаашид компанийн үйл ажиллагааг ашигтай ажилуулах тал дээр төвлөрөн ажиллаж байна. Мөн компанийг өргөжүүлж, шинэ салбарт үйл ажиллагаагаа эхлүүлэхээр төлөвлөж байна. Хот девелопмент ХК хэрэгжүүлэх зорилтууд:

1. Компаний санхүүгийн алдагдлыг бууруулж ашигт ажиллагаанд оруулах
2. Компанийн өр төлбөрийг бууруулах, хөрвүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх
3. Шинэ төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх
4. Хүний нөөц нэмэгдүүлэх /Санхүүгийн шинжээч, нягтлан бодогч/
5. Дотоод зохион байгуулалт сайжруулах шинээр бодлого стратеги тодорхойлох.

Гол хувьцаа эзэмшигч байсан Файрбөрд хөрөнгө оруулалтын сангаас авсан 200,000 ам долларын хөрвөх зээлийг хөрвүүлээгүй байгаа бөгөөд цаашид нэмэлт хувьцаа гаргах компанийн үнэн цэнийг өсгөх зорилгоор уг хөрвүүлэлтийг хийх төлөвлөгөөтэй байна.

Компани нь 2020 онд ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байгаа тул 2020 оны байдлаар 4,719,020 төгрөгийн зардал гаргаж, 26,741,784 төгрөгийн гадаад валютын ханшийн бодит бус гарзтай ажилласнаар 31,397,398 төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Дөлгөөн хайрхан уул ХХК нь 2019 оны жилийн эцсийн тайланд хараат бус аудит хийж дүгнэлт гаргасан ба аудитын дүгнэлтээр Хот Девелопмент ХК-ийн санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж дүгнэжээ.

III. Үнэт цаас гаргагчийн удирдлага

Хувьцаа эзэмшигч

2020 оны 02 сарын 29-ний өдрийн байдлаар "Хот Девелопмент" ХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүтэц дараах байдалтай байна.

№	Хувьцаа эзэмшигч	Хувь
1	"БиДиСЕК ҮЦК" ХК	40.34%
2	"БиДиСи Эй Пи" ХХК	32.84%
3	Б.Лхагвадорж	8.84%
4	5 хүртэлх хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид	17.98%
Нийт		100%

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компани нь 2019 оны 04 сарын 25-ны өдөр хуралдан нийт саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн 82.018% буюу 32,713 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч оролцон хурлын ирц бүрдсэн ба хэлэлцэж буй асуудалтай холбогдож гарсан хурлын шийдвэрийг 100 хувийн саналаар баталсан.

Ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж баталсан байна.

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах.
2. 2018 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах

Компани одоогоор орон тоо болон бүтэц нэмэгдүүлээгүй бөгөөд тайлант хугацаанд Дөлгөөн хайрхан уул ХХК-иар Нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагааг гүйцэтгэн ажиллаж байна.

3. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах

Компани нь 2019 онд үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ салбарт үйл ажиллагаагаа эхлүүлэх тал дээр анхааран дараах зорилтуудыг тавин ажиллахаар шийдвэрлэсэн.

1. Компанийн санхүүгийн алдагдлыг бууруулж ашигт ажиллагаанд оруулах
2. Хүний нөөц нэмэгдүүлэх /Санхүүгийн шинжээч, нярав/
3. Дотоод зохион байгуулалт сайжруулах, шинээр бодлого стратеги тодорхойлох
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж, Н.Батгэрэл, Ш.Шинэбаяр, Г.Гэрэлт-Од, О.Уранбайгаль, хараат бус гишүүдээр Д.Алтай, Б.Алтансүвд, Т.Одням нарыг томилохоор шийдвэрлэсэн байна.

5. Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай

д/д	Зардлын төрөл	Нийт зардал/мян.төг/
1	ТУЗ-ийн хурал зохион байгуулах зардал	400,000
2	Бусад зардал	200,000
	Нийт	600,000

6. ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах

2020 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2020 оны 04 сарын 22-ны өдөр хуралдуулах шийдвэрийг ТУЗ гаргасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл

2019 оны 03 сарын 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг дараах байдалтай сонгосон ба ТУЗ нь хууль журмын дагуу үйл ажиллагаа явуулан ажиллаж байна. 2019 оны 05 сарын 09 -ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын 01 тоот тогтоолын дагуу ТУЗ-ийн даргаар Д.Даянбилгүүнийг сонгосон байна.

№	Овог, нэр	Албан тушаал	Компанийн засаглалын гэрчилгээний дугаар	Компанийн хувьцааг эзэмшдэг эсэх
1	Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн дарга	0420027	үгүй
2	Б.Лхагвадорж	ТУЗ-ийн ердийн гишүүн	0420034	8.84%
3	Н.Батгэрэл	ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал	00048	үгүй
4	Ш.Шинэбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн	0430672	үгүй
5	Г.Гэрэлт-Од	ТУЗ-ийн ердийн гишүүн	0130029	үгүй
6	О.Уранбайгал	ТУЗ-ийн ердийн гишүүн	0430673	үгүй
7	Д.Алтай	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0430689	үгүй
8	Т.Одням	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0430479	үгүй
9	Б.Алтансүвд	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0131078	үгүй

Компанийн тухай хуулийн 75.8 дугаар зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

2019 оны 05 сарын 09 -ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын 02 тоот тогтоолын дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

Цалин, урамшууллын хороо	1. Н.Батгэрэл - /Хорооны дарга/ 2. Д.Алтай 3. Б.Алтансүвд
Аудитын хороо	1. Б.Алтансүвд - /Хорооны дарга/ 2. Т.Одням 3. Д.Алтай
Нэр дэвшүүлэх хороо	1. Д.Даянбилгүүн - /Хорооны дарга/ 2. Д.Алтай 3. Т.Одням

ТУЗ нь өмнөх жилийн ХЭХ-аас хойш 3 удаа хуралдан холбогдох шийдвэр, тогтоолуудыг гаргаж ажиллажээ.

IV. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татварын тайлан тооцоог цаг хугацаанд нь гаргаж, дүүргийн санхүүгийн хэлтэс, татварын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

Санхүүгийн үйл ажиллагаанд одоогоор гарсан томоохон гүйлгээ үл хөдлөх хөрөнгө худалдан авалт хийгдээгүй байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар 14,998,644 төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 808,791,971 төгрөгийн өр төлбөртэй байна.

Үзүүлэлт /төгрөгөөр/	2018	2019
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	44,410,827.64	111,144.52
Авлага	14,887,500.00	14,887,500.00
Нийт эргэлтийн хөрөнгө	59,298,327.64	14,998,644.52
Нийт эргэлтийн бус хөрөнгө	-	-
Нийт хөрөнгийн дүн	59,298,327.64	14,998,644.52
ӨР ТӨЛБӨР		
Татварын өр	23,062.07	7,049.58
Богино хугацаат зээл	528,584,000.00	505,701,200.00
Хүүний өглөг	292,966,096.20	303,009,051.89
Бусад богино хугацаат өр төлбөр	121,098.40	74,670.40
Богино хугацаат өр төлбөрийн дүн	821,694,256.67	808,791,971.87

Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Нийт өр төлбөр	821,694,256.67	808,791,971.87
Эздийн өмч		
Өмч: -хувийн	3,988,500.00	3,988,500.00
Хуримтлагдсан ашиг/алдагдал/	(766,384,429.03)	(797,781,827.35)
Нийт эздийн өмч	(762,395,929.03)	(793,793,327.35)
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	59,298,327.64	14,998,644.52

Компани нь 2019 онд ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байгаа тул 2019 оны жилийн эцсийн байдлаар 4.7 сая төгрөгийн зардал гаргаж, 31.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Зардал өмнөх оныхоос буурсан нь санхүүгийн зардал, гадаад валютын ханшийн зөрүүний гарз буурсантай холбоотой.

Үзүүлэлт /төгрөгөөр/	2018	2019
Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	-	-
Бусад орлого	273,020.60	70,495.06
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	1,383,327.53	4,719,020.35
Санхүүгийн зардал	49,497,562.42	-
Бусад олз (гарз)	-	(38.71)
Бусад ашиг (алдагдал)	(254,580,076.37)	(26,741,784.81)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(305,187,945.72)	(31,390,348.81)
Орлогын татварын зардал	27,302.07	7,049.51
Татварын дараахь ашиг (алдагдал)	(305,215,247.79)	(31,397,398.32)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(305,215,247.79)	(31,397,398.32)

Компани нь тайлант хугацаанд Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна.

Ногдол ашиг

Компанийн тухай хуулийн 46.1, 46.5 дугаар зүйлд заасны дагуу компанийн ТУЗ нь 2020 оны 02 сарын 12-ны өдрийн 20/01 тоот тогтоолоор 2019 онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн.

Энэхүү ТУЗ-ийн шийдвэрийг Компанийн тухай хуулийн 46.2 дугаар зүйлд заасны дагуу компанийн ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.